НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх
зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	**А. Ерөнхий зүйл**
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: **[Говь-Алтай аймгийн Бугат сумын ЕБС]**
ТОӨЗ 1.11	Тендерт оролцогчийн албан ёсны хаяг, мэйл хаяг, холбоо барих утасны 2-оос доошгүй дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар зэрэг мэдээллийг энд оруулсан байна.
ТОӨЗ 1.1*	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: **[Говь-Алтай Бугат сумын ЕБС “Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх**
ТОӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. Багцгүй
ТОӨЗ 1.4	Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаандТОӨЗ 15.9 –ын “а”-д заасан цэгт хүргэх үүрэгтэй.
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн урсгал зардал Нийт батлагдсан төсөв 10856600 төгрөг. Үүнд: Үдийн хоол хөтөлбөр: 53.504.000 Дотуур байрны хоол: 55.062.000 **1 — Мах, сүү сүүн бүтээгдэхүүн — 25000. 000** **2 — Бусад, хүнсний бүтээгдэхүүн — 82.066.000** **3 — Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ — 1.500.000**
ТОӨЗ 4.3	Тендерт оролцогч нь ТОӨЗ-ийн 4.2.1-4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж, эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын

	дагуу холбогдох баримт, нотолгоог тендерт хавсарган захиалагчид ирүүлнэ.

ТОӨЗ 6.1	Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд “Иргэний тухай” хууль, ТШӨХ-ийн 6.1-ийн “а”, “б”, “в”, “г”-д заасан шаардлагыг хангасан түншлэлийн гэрээг байгуулж, гэрээний эх хувийг ирүүлнэ.
Б. Тендерийн баримт бичиг	
Тендерт оролцогчийн бэлтгэн ирүүлэх тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд: I ХЭСЭГ Бүлэг Бүлэг 1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /тайлбар нотлох баримт ирүүлэх/ Бүлэг 2Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт /шалгуур хангасан болохыг нотлох баримтаар ирүүлэх/ Бүлэг 3. Тендер шалгаруулалтын маягт • Тендерийн маягт • Үнийн хуваарь • Тендерийн баталгааны маягт • Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт II ХЭСЭГ Бүлэг 5. Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт III ХЭСЭГ Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл Бүлэг 8. Гэрээний маягт • Гэрээний маягт • Гүйцэтгэлийн баталгааны маягт • Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт	
ТОӨЗ 7.3	Тендерт оролцогч тендерийн баримт, бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх

	шаардлагатай бөгөөд тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, нотлох баримт материалыг ирүүлээгүй байх, маягтыг дутуу ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
ТОӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Тодруулгыг www.umch.khs.gov.mn сайтаар дамжуулан оролцогчид өгнө .Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын **5 хоногоос багагүй байна.**
ТОӨЗ 9.1	Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тендерт оролцогчийн хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээрТөрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системийн тодруулга хэсэгт нийтэлж мэдэгдэнэ.
В. Тендер бэлтгэх	
ТОӨЗ 11.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна. Тендерт оролцогчид дээр тодорхойлсон Монгол хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлнэ. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.
ТОӨЗ 12.1	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) ТОӨЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	1. 2. 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3. 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ нотлох баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) Харилцагч банкинд өр зээлгүй байх Татварын хэлтсийн тодорхойлолт Шүүх байгууллагын тодорхойлолт Үе шатны ажлын хуваарь
4. Тогтмол үнэ	4. 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн	6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш

саналын хүчинтэй байх хугацаа	**45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7.Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	6.2. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 6.3. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 6.4. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	6.5. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний лотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт / Бугат сумын ЕБС-ийн дотуур байр, үдийн цайны хоол, хүнсний материал нийлүүлэх/
ТОЗӨ 1.1	1. Улсын бүртгэлийн гэрчилгээ / гадаад худалдаа/ 2. Сүүлийн 2022,2023 оны санхүүгийн тайлан 3. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл/ гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, акт/ 4. Нийгмийн даатгалын тодорхойлолт / өр төлбөргүй эсэх, эх хувь/ 5. Харилцагч банкны тодорхойлолт / эх хувь/ 6. Татварын хэлтсийн тодорхойлолт / өр төлбөргүй эсэх, эх хувь/ 7. Шүүх байгууллагын тодорхойлолт / эх хувь, анхан шатны шүүхээс/ 8. Шүүхийн шийдвэрийн тодорхойлолт 9. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаах мөн харилцагч банк, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ. 10. ТББ-ийн хуудас бүрийг дугаарлаж , тамга тэмдэг дарсан, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. 11. Тендерийн баримт бичигтэй нэг бүрчлэн танилцаж жишиг маягтын дагуу бөглөж ирүүлэхийг анхаарна уу! 12. Баталгаат хугацаа жил / эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах / 13. Төсөвт өртөг Дээрх материалуудыг ирүүлээгүй буюу дутуу, шаардлага хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
ТОЗӨ 2.1	Тендер хүлээн авах хаяг,эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: **Говь-Алтай аймгийн Бугат сум** Давхар болон өрөөний дугаар: **2 давхар 205 тоот өрөө** Огноо : 2025 оны 04 сарын 18 Цаг**: 15 цаг 00 минут**
ТОЗӨ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг:**Говь-Алтай аймгийн Бугат сум** Давхар болон өрөөний дугаар: **2 давхар 205 тоот өрөө** Огноо : 2025.04.18 Цаг: **15цаг 10 минут**
ТОЗӨ 6.1	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. Багцгүй.

БУГАТ СУМЫН ЕБС-ИЙН 2025 ОНД ХУДАЛДАН АВАХ МАХНЫ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

/ МАХ/

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	❖ Гарал, үүслийн гэрчилгээтэй байна ❖ Өнгө үзэмж сайтай, /1-р зэргийн мах байх/ ❖ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ❖ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх ❖ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна ❖ Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх ❖ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх ❖ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөнбайх ❖ Бусад- **Мах хонь,ямаа**: 1-р зэргийн Улаан ягаан ба улаан, цагаан өөхтэй. Махны өөрийнөвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудсан буюу гадны ямар нэгэн үнэргүй байна. **Мах үхэр:** 1-р зэргийн Улаан ба улаан хүрэн, цайвар шаргал өөхтэй. Тухайн төрлийн махны өөрийн өвөрмөц үнэртэй, чанар байдлаа алдаж муудсан буюу гадны ямар нэгэн үнэргүй байна.

2. **Бараа бүтээгдэхүүнд тавигдах стандартууд/ МАХНЫ/**

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Стандарт
1	Мах /үхэр/	MNS 2457-2009
2	Мах /хонь/	MNS 2456-2009

3. Барааны тодорхойлолт: Бага насны хүүхдэд идэхэд тохиромжтой, зөөлөн эрүүл ахуйн шаардлага хангасан, шинжилгээнд хамрагдсан байна.

Стандарт: Хонь, ямаа, үхрийн 1-р зэргийн мах байна. Махыг дотор эрхтнийг бүрэн гүйцэд авч, гулуузаар бэлтгэсэн байна.

Дулааны улиралд бэлтгэсэн махыг 24 цаг болгон сэврээсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний найрлага:

№	Бүтээгдэхүүний нэр	Ууураг	Өөх тос	Нүүрс ус	Илчлэг	Кальци	Төмөр	Жингийн коэф
1	Хонины 1-р мах	16.3	15.3	0	202.9	9	2	1
2	Ямааны 1-р мах							
3	Үхрийн 1-р мах	19.8	12.4	0	187.2	9	2.6	1

Мах, махан бүтээгдэхүүнд: Бага насны хүүхдийн хооллолт нь хүүхдийн хоногийн хэрэгцээ, тэднийөсөлт хөгжилттэй уялдан өөрчлөгдөж байх бөгөөд бие бялдар сэтгэхүйн хэвийн өсөлт хөгжилтийгбүрэн хангахуйц хэмжээний ууураг, өөх тос, нүүрс ус, эрдэс бодис, амин дэм агуулсан бага насныхүүхдэд тохирсон зөөлөн амт чанартай мах нийлүүлнэ.Ясны хорогдол их гардгаас шалтгаалан махны хэмжээ багасдаг. Иймээс махны гарц ихтэй бага насны малын мах нь илүү тохиромжтой байдаг. Мах махан бүтээгдэхүүнийг ариун цэврийн шаардлага хангасан үл зэврэх металлаар доторлосон битүүтэвштэй тусгай зориулалтын машинаар тээвэрлэнэ.

Тусгай шаардлага:

1. Бараа материалыг тухай бүр цаг алдалгүй нийлүүлж байх
2. Шаардлагад нийцээгүй бараа бүтээгдэхүүнийг буцаах ба түүнээс үүсэх хохирлыг нийлүүлэгч тал өөрсдөө хариуцна.
3. Өөрийн бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийг /шаардлагатай бол тухай бүр/ улирал бүрийн эхэнд сургуулийн захиргаанд өгч байх.

5.Шалгалт,туршилт

Бугат сумын ЕБС-ийн техникийн тодорхойлолтонд заасны дагуу шалгаж хүлээж авна.

Барааг сургуулийн нярав Г.Чулуунцэцэгт хүлээлгэн өгнө.

БУГАТ СУМЫН ЕБС

Дөрөв. БУГАТ СУМЫН ЕБС-ИЙН 2025 ОНД ХУДАЛДАН АВАХ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: Хүүхэд идэхэд тохиромжтой, элдэв гаж нөлөөгүй, хүүхдийн биед шингэц сайтай, илчлэг, эрдэс ихтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан

2. Стандарт: Хүүхдийн биед тохирсон, хүнсний зориулалтын, хадгалах хугацаа тодорхой, химийн найрлагагүй, шинжилгээнд хамрагдсан, чанарын баталгаатай бүтээгдэхүүн байна. Хүнсний олон улсын стандартад тохирсон. Хугацаа хэтэрсэн бараа хүлээн авахгүй..

3. Хүнсний бүтээгдэхүүний улирал бүр шинжилгээний газарт өгч шинжилгээг хийлгэнэ. Шаардлагатай үед хугацаа болоогүй ч гэсэн шинжилгээнд хамруулна.

4. Баглаа боодол: Гадна бохирдол ус чийгнээс хамгаалагдсан тусгай савлагаатай, зарим бүтээгдэхүүн нь 1-5 кг-аар савлагдсан байж болно.

/ БУСАД ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН 1 /

Хүнсний төрлийн бүтээгдэхүүн:

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	➢ Өнгө үзэмж, амт, чанарын шаардлага хангасан байх ➢ Зориулалтын агуулахтай байх ➢ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ➢ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх ➢ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. ➢ Сав, баглаа боодлын стандарт шаардлага хангасан байна. ➢ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх ➢ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтад тусгаж өгсөн байх ➢ Үйлдвэрлэсэн огноо, ашиглагдах хугацаа шаардлага хангасан байх ➢ Нийлүүлэгч нь 2-оос доошгүй жил ажилласан байна. ➢ БГ-055, БГ-085, БГ-075, БГ-115 ангилалын гурил нь1,2 -р зэргийн буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн болон гашуун чихэрлэг амтгүй,зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл зажлагдахгүй байх. ➢ **Будаанууд**: Жижиглэж болон уутаар савласан, ургалт бүрэн гүйцсэн, бөөрөнхий хэлбэртэй, элдэв хог хаягдалгүй, хээгүй ➢ **Элсэн чихэр:** Жигд нарийн ширхэгтэй, цагаан өнгөтэй, өөрийн төрлийн үнэртэы чихэрлэг амттай, уусалт сайн, гадны хольцгүй. ➢ **Ургамлын тос, самрын тос**: Цайвар шар өнгөтэй, тунадас үүсээгүй, зориулалтын саванд савласан гаж үнэргүй, өөрийн амттай. ➢ **Давс:** Иоджуулсан, зориулалтын уутанд савласан ➢ **Гоймонгууд:** Гадаргуу нь шулуун эржгэр, долгиолсон, хөндий, туузан хэлбэртэй, нэр төрөл ангилалдаа тохирсон элдэв амт, үнэргүй хөгцөрсөн гашуун, исгэлэн буюу гадны үнэр амтгүй, савлалт тээвэрлэлтийн явцад үйрч няцраагүй, шаргал буюу цайвар шаргал өнгөтэй. чийглэг, хүчиллэг, төмөрлөгийн үзүүлэлт нь чанарын

	шаардлага хангасан зөвшөөрөгдөх хэмжээнд байна. ➢ **Хөөлгөгч**: Шаргал туяатай, сааралдуу өнгөтэй, бараан толбогүй, гадны ямар нэгэн амтгүй,задлахад нунтаг байдалтай, хуурай наалдаагүй, хадгалах хугацаа хэтрээгүй. ➢ **Үзэм:** Хүрэн бор, шаргал өнгөтэй, чихэрлэг, гадны гаж амтгүй, шороо чулуугүй, эрүүл ахуйн шаардлага хангасан. ➢ **Харчавга,чацаргана, нэрс** эдгээр нь өөр өөрийн төрлийн үнэр амттай,гадаргуу биет гэмтэлгүй, хортон шавжны бохирдолгүй, чихрийн талстгүй, чихэрлэг хуурай бодис 72,5% -тай байх. Жимс жимсгэний хурц үнэртэй өөр төрлийн бараатай хамт тээвэрлэхийг хориглоно.Түргэн гэмтдэг барааг тусгай зориулалтын машинаар чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэнэ.

Хүнсний аюулгүй байдал, хорио цээрийн шаардлагыг хангасан байх. Үүнд: Сав баглаа боодол гэмтээгүй, гадны бохирдолгүй, хогт хольцгүй, ургамлын гадаад дотоод хорио цээргүй, хөнөөлт шавжгүй, хөгц мөөгөнцөр илрээгүй, өөрийн төрөлдөө тохирсон үнэр амт, нэр төрлийн дагуу өнгөтэй, хуурай нунтаг, бөөгнөрсөн хэсэггүй байх. Мөн химийн шинжилгээгээр хүчиллэг, чийглэг, цавуулаг, үнслэг чанар нь стандартад тохирч байх шаардлагатай. Хадгалалт, савлалт, борлуулалтын явцад бүтээгдэхүүн тус бүрийг тодорхой үзүүлэлтээр улирал бүр шинжилгээнд харуулсан шинжилгээний бичгийг авчирч өгсөн байна.

Талх, нарийн боовны техникийн тодорхойлолт

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	➢ Өнгө үзэмж, амт, чанарын шаардлага хангасан байх ➢ Зориулалтын агуулахтай байх ➢ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ➢ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх ➢ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. ➢ Сав, баглаа боодлын стандарт шаардлага хангасан байна. ➢ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх ➢ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтад тусгаж өгсөн байх ➢ Үйлдвэрлэсэн огноо, ашиглагдах хугацаа шаардлага хангасан байх

Хүнсний ногооны техникийн тодорхойлолт

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	➢ Өнгө үзэмж, амт, чанарын шаардлага хангасан байх ➢ Зориулалтын агуулахтай байх ➢ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ➢ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх ➢ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна. ➢ Сав, баглаа боодлын стандарт шаардлага хангасан байна. ➢ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх ➢ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтад тусгаж өгсөн байх ➢ Үйлдвэрлэсэн огноо, ашиглагдах хугацаа шаардлага хангасан байх **Хүнсний ногооны төрөлд** : төмс, байцай, сонгино,лууван, манжин, хүрэн манжин, цэцэгт байцай, улаан лооль, өргөст хэмх багтана. ➢ **ТӨМС**: 1-р зэргийн шинэ эрүүл, шар өнгөтэй, өвчин, хөнөөлт шавжаар гэмтээгүй бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна. ➢ **ЛУУВАН:** 1-р зэргийн шинэ эрүүл, өнгө нь жигд хэвийн сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан, хальс нь үрчийгээгүй, гадна амт үнэргүй байна.Нягт шүүслэг, голч 1,9-2,8 см байх шаардлагатай. ➢ **БАЙЦАЙ:** 1-р зэргийн толгой нь нягтарсан шинэ, бүтэн цэвэр, гадны үнэр амтгүй, хөлдөлт хайрагдалтгүй, өнгө цайвар ногооноос цагаан байна. ➢ **СОНГИНО:** Ялзарч муудаагүй, чанартай, эрүүл, шинжилгээний бичигтэй хүнсэнд хэрэглэхэд үнэртэй шинэ байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Стандарт
1	Аарц	MNS4230:2005 MNS5547:2005 MNS4990:2000
2	Тараг	MNS4230:2005 MNS5547:2005 MNS4990:2000

Бүтээгдэхүүний найрлага:

№	Бүтээгдэхүүний нэр	Ууураг	Өөх тос	Нүүрс ус	Илчлэг	Кальци	Төмөр	Жингийн коэф
1	Сүү / милко, өглөө, цэвэр,зөв/	3,1	3,2	5,0	62	65,2	0,1	1
2								

Сүү, сүүн бүтээгдэхүүнд: Сүү, аарц, тараг, ээзгий, ааруул багтдаг. Гадны бохирдолгүй сүү, сүүн бүтээгдэхүүний ариун цэврийн шаардлага хангасан

гэрчилгээтэй, амт үнэр сайтай, гашлаагүй, сав баглаа боодол гэмтэлгүй битүү саванд хурааж тээвэрлэсэн, чийглэг нь тохирсон, гашлах болсон гашуун элдэв төрлийн амт үнэргүй байна.

БУГАТ СУМЫН ЕБС-ИЙН ДОТУУР БАЙРНЫ ХООЛ, ҮДИЙН ЦАЙНЫ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

2023 оны

	Нэр төрөл	Барааны гарал үүслийн улс	Жилийн нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1		2	3	4	5	6	7
1	Гурил УБ	Монгол	1500кг	1140	1.710.000		1.710.000
	Гурил АТ	Монгол	1500кг	1120	1.680.000		1.680.000
	Бүхэл үрийн гурил	Монгол	50кг	1800	90.000		90.000
2	Цагаан будаа	Орос	1000кг	2500	2.500.000		2.500.000
3	Гурвалжин будаа	Орос	200кг	3500	700.000		700.000
4	Хөц будаа	Орос	80кг	2500	200.000		200.000
5	Шар будаа	Орос	220кг	3600	792.000		792.000
6	Элсэн чихэр	Орос	250кг	2300	575.000		575.000
7	Давс	Монгол	110кг	1000	110.000		110.000
8	Хөөлгөгч 500гр	Орос	10кг	4500	45.000		45.000
9	Жигнэмэг	Орос	3000ш	1500	4.500.000		4.500.000
10	Задгай вафли	Орос	3000ш	9000	2.700.000		2.700.000
11	Далайн байцай	Солонгос	200ш	3000	600.000		600.000
12	Каш	Орос	50кг	2500	125.000		125.000
13	Масло/ цөцгийн тос/	Орос	100кг	5000	500.000		500.000
14	Хүнсний сод 750гр	Орос	12кг	4000	48.000		48.000
15	Цай / их тайга/	Орос	18ш	3500	63.000		63.000
16	Ногоон цай	Хятад	5 хайр	21000	105.000		105.000
17	Гоймон / шпагетти/	Орос	10кг				
18	Гоймон	Монгол	10кг				
19	Үзэм	Орос	380кг	7000	2.660.000		2.660.000
20	Тараг	Монгол	400л	4500	1.800.000		1.800.000
21	Бяслаг / сыр/	Орос	120ш	3500	420.000		420.000
22	Чацаргана /задгай/	Монгол	200кг	7500	1.500.000		1.500.000
23	Чацаргана -Увс	Монгол	40л	6500	260.000		260.000
24	Алимны нухаш	Орос	150ш				
25	Алим	Орос	50кг	5500	275.000		275.000
26	Хатаасан жимс	Орос	40кг	11000	440.000		440.000
27	Чанамал/ варень/	Орос, М	150ш	4000	600.000		600.000
28	Аньсны шүүс	Монгол	50л				
29	Ургамлын тос	Орос	50л	4500	225.000		225.000
30	Самрын тос	Орос	120л	3500	420.000		420.000
31	Пакеттай сүү	Монгол	500л	3500	1.750.000		1.750.000

32	Хар талх	Монгол	200ш	1200	240.000		240.000
33	Гамбир	Монгол	200ш	3800	760.000		760.000
34	Пүнтүүз						

ХҮНСНИЙ НОГОО

	Нэр төрөл	Барааны гарал үүслийн улс	Жилийн нийт хэрэгцээ	Нэгж үнэ	Нийт үнэ	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	Төмс	Монгол	1800кг	1500	2.700.000		2.700.000
2	Манжин	Монгол	250кг	1500	375.000		375.000
3	Лууван	Монгол	250кг	1500	375.000		375.000
4	Байцай	Монгол	1000кг	2000	2.000.000		2.000.000
5	Сонгино	Монгол	20кг	2500	50.000		50.000

БУГАТ СУМЫН ЕБС-ИЙН ЗАХИРГАА